

**"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04-р сарын 28-ний өдөр

Улаанбаатар хот

"Улсын их дэлгүүр" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, "Номин юнайтед" төвийн 4.5 дугаар давхарт биечилсэн хэлбэрээр зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахимаар оролцсон хувьцаа эзэмшигч байгаагүй.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04-р сарын 20-ны өдрийн 25/05 дугаартай тогтоолоор томилогдсон хурлын дарга Я.Наваан, тооллогын комиссын дарга, эдийн засагч Г.Өсөхбаяр, тооллогын комиссын гишүүн хуульч Ч.Нарангэрэл, нягтлан бодогч Н.Сүрэнжав, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат нарын бүрэлдэхүүнтэйгээр хурлын үйл ажиллагааг зохион байгуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зард тусгасны дагуу хуралд биечлэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн иргэний цахим үнэмлэх, бичиг баримтыг шалгасны үндсэн дээр Тооллогын комисс хурлын ирцийг бүртгэх ажлыг 09:20 цагаас 10:15 цаг хүртэл хугацаанд хийв.

Хурлын үйл ажиллагааг 10:15 цагт эхлүүлэв.

Хурлын дарга Я.Наваан: "Улсын их дэлгүүр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 28-ний өдөр биечилсэн болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулах тухай шийдвэрийг Толоолон удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 20-ны өдрийн хурлаас гаргасан. Гэхдээ энэ удаагийн хуралд цахим хэлбэрээр оролцож буй хувьцаа эзэмшигч байхгүй байна. Мөн энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах эрхийг ТУЗ-ийн дарга Я.Наваан надад олгосон. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг Г.Өсөхбаяр, Ч.Нарангэрэл, Н.Сүрэнжав гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Ингээд "Улсын их дэлгүүр" ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байгааг мэдэгдье.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг ТУЗ-өөс баталсныг та бүхэнд танилцуулъя.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
2. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах.
3. ТУЗ-ийн гишүүдийг нөхөн болон улируулан сонгох.

Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. Тооллогын комисс хурлын бүртгэл хийж, ирц танилцуулах ажлыг хийнэ. Үүний дараа хурлын дарга миний бие хурлаар хэлэлцэх 3 асуудалтай холбоотой танилцуулгыг та бүхэнд хүргэнэ. Дараа нь ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулна. Дараа нь хувьцаа эзэмшигчдээс үг хэлэх, санал гаргах үе шат эхэлнэ. Дараа нь хурлаар хэлэлцсэн асуудалд саналын хуудсаар санал хурааж, тооллогын комисс санал хураалтын үр дүнг танилцуулж, хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулснаар хурлын үйл ажиллагаа дуусна.

Хувьцаа эзэмшигч Ганболд, Дашзэвэг нар: Хурлын дэгэд санал байна. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрийн танилцуулгын дараа хувьцаа эзэмшигч нар асуултаа асуугаад саналаа хэлээд явмаар байна.

Хурлын дарга Я.Наваан: За та бүхний саналын дагуу хурлын дэгээ өөрчлөөд явъя. Ингээд хурлаа эхлүүлье. Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Өсөхбаяр: Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 19,579,789 ширхэг хувьцааны саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу компанийн нийт хувьцааны 53.19%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцож байгаа учраас Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хурлын ирцийг хүчинтэйд тооцож байна.

Нийт 42 хувьцаа эзэмшигч урьдчилан саналын хуудсаар саналаа өгснийг хурлын ирцэд оруулан тооцсон болно. Хуралд 20 хувьцаа эзэмшигч биечлэн оролцож байна.

Хурлын дарга Я.Наваан: За хуралд нийт хувьцаа эзэмшигчдийн 53.19% нь оролцож байгаа учир хурлын ирц хүчин төгөлдөр болж байна. Хурлын ирц бүрдсэн учраас хурлын үйл ажиллагааг эхлүүлье. Хурлаар хэлэлцэх нэгдүгээр асуудал буюу компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах асуудалд оръё. Компанийн үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга миний бие танилцуулъя. Хувьцаа эзэмшигчдэд энэхүү мэдээлэл материалыг брокерын компаниудаар дамжуулан урьдчилан хүргүүлсэн байгаа.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН НЭГДҮГЭЭР АСУУДАЛ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар

2024 онд “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Я.Наваан, И.Галбуян, А.Норсмаа, Х.Эрдэнэбаатар, Т.Сарантуяа, Т.Амартөр, нар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр М.Дамирансүрэн, Н.Энхчимэг, М.Ганцацэг нар, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар М.Өлзийбат, компанийн Гүйцэтгэх захирлаар Х.Эрдэнэбаатар нар ажиллалаа.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн хэтийн төлөв, зорилтыг тодорхойлон хууль, дүрэм, журамд заасан эрх үүргийнхээ хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, түүний дэргэдэх хороод нь хороосны эрх мэдлийн хүрээнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөл тайлант хугацаанд нийт 6 удаа биечлэн хуралдаж, 4 удаа эцнээ санал хураалтаар шийдвэр гаргаж, гүйцэтгэх удирдлагын шийдвэрлүүлэхээр санал оруулсан асуудлуудыг цаг тухайд нь бүрэн шийдвэрлэж ажилласан.

Компанийн санхүүгийн нөхцөл байдлын талаар:

“Улсын Их Дэлгүүр” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу түрээслэгч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр түрээсийн талбарөө үе шаттай нэмэгдүүлж, сүүлийн 4 жилийн хугацаанд түрээсийн үнээ 53%-иар өсгөөд байна. 2024 онд нийт 11,038.8 сая төгрөгийн түрээсийн орлоготой, 3,361.4 сая төгрөгийн ашигтай ажилласан. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан хүмүүст холбогдох иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн Шүүхийн шийдвэрийн дагуу “Номин Реалтор” ХХК-иас төлөгдсөн 2,400.0 сая төгрөгийн орлого дээрх ашгийн дүнд орсон болно.

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны зардал 7,698.3 сая төгрөг байна. Үйл ажиллагааны зардлын 2.0 хувийг хөдөлмөрийн зардал, 45.7 хувийг ашиглалтын зардал, 0.1 хувийг барилгын урсгал засварын зардал, 17.6 хувийг хөрөнгийн элэгдлийн зардал, 27.4 хувийг зээлийн хүүгийн зардал, 2.8 хувийг үл хөдлөх хөрөнгийн болон газрын татвар, 2.4 хувийг даатгалын зардал, 2.2 хувийг бусад зардал эзэлж байна. Үйл ажиллагааны бус орлогын хувьд банкны харилцах дансанд тооцсон хүүгийн орлого 3.1 сая төгрөг байна.

2024 онд нийт хөрөнгийн дүн 14,087.0 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 1.0 хувь буюу 158.7 сая төгрөг байна. Эргэлтийн хөрөнгийн 30.0 хувийг банкны харилцах дансны үлдэгдэл,

11 хувийг татварын авлага, 19 хувийг хангамжийн материал, 40 хувийг урьдчилж төлсөн зардал буюу даатгалын зардал эзэлж бна.

Нийт хөрөнгийн дүнд эргэлтийн бүс хөрөнгө 99 хувь буюу 13,928.3 сая төгрөгийг эзэлж байгаагийн 73.2% буюу 10,201.2 сая төгрөгийг барилга байгууламж, 22.3% буюу 3,115.3 сая төгрөгийг машин тоног төхөөрөмж, 0.5 сая төгрөгийг тавилга эд хогшил, үлдэх 4.5% буюу 611.3 сая төгрөгийг хөрөнгө оруулалт болон хойшлогдсон татварын хөрөнгө эзэлж байна.

Оны эхэнд дансны авлага 16.9 сая төгрөг, оны эцэст 17.4 сая төгрөг байна. Авлагыг ангилж үзвэл НӨАТатварын авлага 3.1 сая төгрөг, орлогын албан татварын авлага 14.2 сая төгрөг, бусад авлага 0.1 сая төгрөг байна.

Оны эхэнд 592.2 сая төгрөгийн богино хугацаат өглөгтэй байснаас оны эцэст 1,146.4 сая төгрөг болсон.

2024 онд "Улсын Их Дэлгүүр" ХК нь Шүүхийн шийдвэрийн дагуу хөндлөнгийн Аудитын зөвлөмжид үндэслэн 5 этгээдэд төлөх ёстой талын хохирлын 5,063.7 сая төгрөгийн өглөгийг дансанд бүртгэж, нийт 4,263.7 сая төгрөгийн төлбөрийг төлж барагдуулан оны эцэст энэ гооцооноос 1 этгээдэд хамаарах 800.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Үлдэх 348.4 сая төгрөгөөс 189.0 сая төгрөг нь эзэлийн хүүгийн өглөг, 80.7 сая төгрөг нь холбоотой талын өглөг, 28.9 сая төгрөг нь цалин, НДШ татварын өглөг, 67.9 сая төгрөг нь дотоодын харилцагчид төлөх ёстой /УСУГ, ДШСГ, барьцаа/ өглөг байна.

Компанийн үйл ажиллагааны талаар:

Компани нь татвараа үнэн зөв тодорхойлох, төлөх, тайлагнах үүргээ бүрэн биелүүлж, 2024 онд НӨАТатварт 628.2 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 184.4 сая төгрөг, ХХОАТатварт 13.3 сая төгрөг, НДШимтгэлд 18.6 сая төгрөг, газрын татварт 13.9 сая төгрөг, нийт дүнгээр 858.4 сая төгрөгийг Монгол улсын төсөвт төвлөрүүлсэн.

2024 онд Улсын Их Дэлгүүрийн барилгын 1-р давхрын гадна талын хатаасан бор шил, 2 – 6-р давхрын цонхны хагарсан шил солих, 6-р давхрын шалны хулдаас наах, 3-р давхрын зүүн жигүүрт агааржуулалтын хослойд 9 ширхэг гар хавхлаг суурилуулах, 2-р давхрын агаар сорох хэсгийн шинэ холболтыг хийх, 3 болон 5 дугаар давхрын урд хэсэгт систем кондейшин суурилуулах, 7-р давхарт хиншүү сорох шугамын төгсгөлийг гадагш гаргах, урд авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээг будаж шинэчлэх зэрэг барилгын чанар байдлыг хадгалах, орчин нөхцлийг сайжруулахтай холбоотой ажлуудыг хийх гүйцэтгэлээ.

Аудитын байгууллагын зөвлөмжийн талаар:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар сонгогдсон хөндлөнгийн аудитын байгууллага болох "Сүлд-Аудит" ХХК-ийн зүгээс "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэл нь Монгол Улсын Сангийн Яамнаас баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт", "Дансны үлгэрчилсэн заавар"-ын дагуу ажруул сууриар бэлтгэгдсэн ба энэхүү тайлагналын суурь нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцэж байна гэсэн дүгнэлт өгсөн.

Ингээд та бүхэнд компанийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүдийг харуулъя. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд та бүхэнд урьдчилан тараагдсан хурлын танилцуулга материалд бас орсон байгаа (гээд доорх мэдээллийг дэлгэц дээр харуулав)



**"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ийн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨД**

ТӨЛӨӨЛӨХ ДҮГНЭЛТ

Бид "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-н өдөр санхүүгийн байршил
тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн зөрчлөлтийн тайлан, мөнгөн
гүйцээжийн тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой
нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит
хийлээ.

2024.12.31 2024.12.31

Бид "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-н өдөр санхүүгийн байршил

Бид "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-н өдөр санхүүгийн байршил

Барилгатгүй дүгнэлт

Бид "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-н өдөр санхүүгийн байршил
тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн зөрчлөлтийн тайлан, мөнгөн
гүйцээжийн тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой
нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит
хийлээ.

Бидний дүгнэлтээр хявсаргасан санхүүгийн тайлангууд нь "Улсын Их Дэлгүүр" ХК-ийн 2024
оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байршил, энэ өдөрөөр тасалбар болсон жилийн
орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйцээж бүх материаллаг зүйлсийн хувьд
Санхүүгийн Тайлангын Олон Улсын Стандарт (СТОУС)-нд нийцүүлэн, Монгол улсын
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар, журмын дагуу бүх
материаллаг зүйлсийг хамруулсан үнэл зөр бодотой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ны дагуу хийсэн. Эдгээр стандартын
дагуу хүлээх хариуцлагаа ажхуу тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын
хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар
санхүүгийн тайлангийн аудитад таамаглах ёс зүйн шаардлагатай дагуу ёс зүйн үүрэг
хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт
гарахад, хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын нэргээлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн
санхүүгийн тайлангийн аудитад үнэмж нэлээ үзүүлсэн асуудлууд байдгай. Эдгээр асуудлыг
бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн
талбар аудиторын дүгнэлт гарахад зөв үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь
дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг хариуцлага хүлээнэ. Бусад мэдээгэл гэдэгт санхүүгийн тайланг орсон мэдээллийг хамруулах ойлгох ба санхүүгийн тайланг өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд уулд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын орон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэх, үнэн зөв шударгаар талинуулах болон залилан юмуу алдаанаас үндэлтэй материаллаг алдаанаас өртөд санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар эсвэл нилэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг өшиглөх үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас уудах материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дөнгөжөө болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол мөнгөжиллэг гэж үзнэ.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу эвхэн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр алмаа нэг гүйцэтгэл, тайлан өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн

Сүлд-Аудит ХХК

Гүйцэтгэх Захирал /МНБ/

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Сүлд-Аудит

Ч. ГҮНДБАЯР

Ч. ГҮНДБАЯР

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХЯВСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөх

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2023	12/31/2024
А.ХӨРӨНГӨ			
1.Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1	234,811.20	47,671,547.23
Дансны эзлэл	2	-	390,000.00
Татаар, НДШ-ийн нөлөө	2	704,282,423.28	17,386,424.31
Бусад эзлэл	2	-	-
Бяраа материал	3	132,244,536.48	29,441,528.47
Урьдчилж төлсөн зардал гэхцэр	4	9,464,568.52	63,846,903.22
Эргэлтийн хөрөнгийн дүн		846,226,398.48	153,736,503.23
2.Эргэлтийн бус хөрөнгө			
Үүдсэн хөрөнгө	5	14,315,710,599.92	13,517,022,054.90
Бусад бус хөрөнгө		-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6	33,811,920.00	33,811,920.00
Хойшлогдсон татаарын хөрөнгө	7	-	18,657,260.27
Бусад эргэлтийн бус хөрөнгө	8	-	558,560,700.84
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		14,349,522,519.92	13,928,291,035.81
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		15,195,748,918.40	14,087,028,439.04
Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
1.Өр төлбөр			
Дансны өглөг	9	266,067,835.10	928,554,331.13
Цалингийн өглөг	10	3,556,128.23	6,671,477.19
Татаарын өр	10	61,435,912.63	6,596,409.37
НДШ-ийн өглөг	10	18,152.42	220,396.62
Хүүний өглөг	11	114,657,034.25	198,972,902.75
Ногдсон ашгийн өглөг	11	15,433,581.00	15,433,581.00
Урьдчилж орсон бөлөг	12	100,000,000.00	-
Бусад богино хугацаат өр төлбөр	11	980,674.13	946,675.33
Богино хугацаат өр төлбөрийн дүн		592,225,815.76	1,146,394,473.64
Урт хугацаат зээл	10	17,000,000,000.00	17,000,000,000.00
Хойшлогдсон татаарын өр		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		17,000,000,000.00	17,000,000,000.00
Өр төлбөрийн нийт дүн		17,592,202,852.42	18,146,394,473.64
2.Эздийн өмч			
а.Төрийн			
б.Хувийн			
а. Хувьцаат	13	3,680,785,000.00	3,680,785,000.00
Халасны хувьцаа	13	(175,984,106.00)	(175,984,106.00)
Намж төлөгдсөн капитал	13	133,351,798.00	133,351,798.00
Хөрөнгийн дохио үзлэгзний нэмэгдэл	14	1,600,064,101.82	1,600,084,101.82
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг, аг дэгдэл	15	(7,634,733,691.13)	(9,297,672,878.42)
Эздийн өмчийн дүн		(2,398,476,897.36)	(4,069,366,034.56)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		15,195,748,918.40	14,087,028,439.04

Хавсаргасан гэмдэлснүүд нь эзэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг боловч



УНСЫНЖ ДЭЛГҮҮР ХК
АЖИРТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдөрөөр

Даяарчээр?

ҮЗҮҮЛЭЛТ	Төл	12/31/2023	12/31/2024
Борлуулалтын орлого (цэвэр)	16	8,310,638,334.25	11,038,755,559.00
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг (алдагдал)		8,310,638,334.25	11,038,755,559.00
Түрээсийн орлого		-	-
Хүүгийн орлого	17	-	2,880,143.35
Ногдол ашигын орлого		-	-
Эрхийн ашигтайн орлого		-	-
Бусад орлого	17	-	309,091.00
Борлуулалт, нэрлэхүйн зардал	18	4,954,860.04	5,384,870.20
Гэрмий ба удирдлагын зардал	18	5,469,870,912.08	5,582,032,641.64
Санхүүгийн зардал	19	1,579,958,904.13	2,111,575,342.47
Бусад зардал	18	17,775,538.58	95,208.82
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-	-
Үндсэн хөрөнгө даяснаас хассаны олз (гарз)		-	-
Бусад бусад хөрөнгө даяснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас ууссан олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)	20	(1,031,907,285.00)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		106,577,286.43	3,361,442,896.15
Орлогын татварын зардал	21	-	(10,609,245.93)
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)		106,577,286.43	3,361,442,896.15
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		106,577,286.43	3,361,442,896.15
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Хөрөнгийн дахин үнэлэхний нэмэгдлийн зөрүү		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-
Бусад олз (гарз)		-	-
Орлогын нийт дүн		106,577,286.43	3,361,442,896.15
Нэлж хувицаанд ногдох суурь ашиг (алдагдал)		-	-

Хавсаргасан гэхдээ нэлж хувицаанд ногдох суурь ашиг (алдагдал) нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



За ингээд хурлаар хэлэлцэх 1-р асуудалтай холбоотой танилцуулгыг хийж дууслаа. Компанийн тухай хуульд заасны дагуу хувицаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулъя.

Компани тайлант жилийн болон өмнөх онуудад бий болсон хуримтлагдсан ялдагдлаа нөхөж чадаагүй, мөн Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 517 дугаартай тогтоолын дагуу Улсын их дэлгүүрийн барилгад гарсан гал түймэртэй холбогдуулан бусдад учирсан хохирлыг нөхөн төлсөн зэргээс үүдэн Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан "ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх", "ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх" шаардлагуудыг хангаж чадахгүй байх тул 2024 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

За одоо хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуух, санал гаргах, үг хэлэх хүмүүс байвал урьдчилж нэрээ хэлээд дарааллын дагуу яриад явъя.

Хувьцаа эзэмшигч Мөнхтөгс: Миний зүгээс нэг санал хэлэх гэсэн юм. Компанийн санхүүгийн тайланд Сүлд-Аудит компаниар аудит хийлгэсэн юм байна. Энэ аудит хийсэн компанийн танилцуулгыг хувьцаа эзэмшигч нарт үзүүлж байвал бас зүгээр байна. Дотоодын компани юм уу эсвэл гадны компани юм уу, хэр зэрэг туршлагатай компани вэ гэдгийг бид бас мэдэж байвал зүгээр байна. Мөн энэ хурлын танилцуулга материалд компанийн санхүү байдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан зэрэг гол үзүүлэлтүүд нь орсон байна. Санхүүгийн тайланг бүхлээр нь бас олж үзмээр байна.

Хурлын дарга Я.Наваан: За таны саналыг ойлголоо. Та ТУЗ-ийн нарийн бичгийн даргаруу и-мэйл хаягаа явуулаад санхүүгийн тайланг бүтнээр нь авч танилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: Богино хугацаатай өглөг оны эцэст 1,046,000,000 төгрөг болсон гэж байна. Энэ ямар учиртай ингээд өглөг нэмэгдчихвээ?

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: За энэ өглөг нь 2020 оны гал түймрийн хохиролтой холбоотой шүүхийн шийдвэрийн дагуу компаниас бусдад төлөх ёстой өр төлбөрөө тайланд бүртгэсэн гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: Галын хохиролтой холбоотой нийт өр төлбөр хэдэн төгрөгөөр бичигдсэн бэ? Хэд нь төлөгдөөд хэд нь үлдээд байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Галын хохиролтой холбоотой нийт 5 тэрбум гаруй төгрөг бусдад төлөхөөр болсон. Эндээс 1 тэрбум орчим төгрөг нь 2023 онд төлөгдсөн. 3 тэрбум гаруй төгрөг нь 2024 онд төлөгдсөн. Одоо 800 сая орчим төгрөгийн төлбөр төлөгдөхөөр хүлээгдэж байгаа. Энэ онд төлж дуусах эсэхийг бид мөнгөн урсгалаа харж байгаад шийднэ.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: За дахиад нэг гүнзгийрүүлээд асуух юм байна. Улсын их дэлгүүрийн барилгыг Номин реалтор ХХК-д түрээслүүлж байгаа. Гэтэл барилгад гал гарсны хохирлыг яагаад Улсын их дэлгүүр компани хариуцахаар болсон юм бэ?

Хурлын дарга Я.Наваан: Энэ 2020 оны 6-р сард гарсан галын хохирол. Шүүхийн маргаан нь 3 жил үргэлжлээд 2023, 2024 онд шийдвэрлэгдсэн. Энэ дээр галын хохиролтой холбоотой эдийн засгийн гэм хорыг нь хамтран арилгах, хариуцах этгээд гэж шүүхээс Улсын их дэлгүүр компанийг тогтоосон. Улсын их дэлгүүрийн барилгад талбай түрээслэж байсан түрээслэгч нарын бараа материалд учирсан хохирлыг барилгын дээвэр дээр ажил хийж байсан Ай ти эн ХХК гэж гүйцэтгэгч компанигай 50, 50 хувиар хамтран хариуцахаар болсон. Шүүх ингэж шийдэхдээ Улсын их дэлгүүр компани Барилгын тухай хуульд заасан барилгын өмчлөгч этгээд нь барилгын дээвэр дээр хийгдэж байсан засварын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзээд Улсын их дэлгүүр компанийг хамтран хариуцагчаар татаж нийт хохирлыг хуваан төлүүлэхээр шийдвэр гаргасан юм.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: Номин компани галын хохирлыг нөхөн төлөхөд оролцсон уу?

Хурлын дарга Я.Наваан: Энэ гал түймрийн аюулаас үүдэн Номин холдинг ХХК болон түүний нэгдэлд хамаарах компаниуд тэдгээрийн хувьцаа эзэмшигчид бас нэлээдгүй хэмжээний хохирол амссан. Яг нарийн тоог нь одоо шууд хэлж мэдэхгүй байна. Номингийн зүгээс галын улмаас түрээслэгч нарт учирсан хохирлын дүнг бууруулахад чухал нөлөө үзүүлж ажилласан. Нэлээдгүй хэмжээний дүнг бууруулж чадсан. Үүний үр дүнд Улсын их дэлгүүр компанид ногдсон хохирол төлөх дүн багассан байдаг.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: Татварын өмнөх ашиг 2023 онд 106 сая төгрөг юм шиг байна. Тэгснээ 2024 онд 3.3 тэрбум төгрөг болж өссөн байна. Энэ юунаас болоод ингэж огцом өссөн бэ?

Хурлын дарга Я.Наваан: За энэ өсөлт нь болохоор түрүүн танилцуулга дээр дурдагдсан Улсын их дэлгүүр компанийн ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой шүүхийн маргаан бас явж байсан. Тухайн шүүхийн шийдвэрийн дагуу компани 2024 онд 2.4 тэрбум төгрөгийн төлбөр хүлээж авсан. Энэ нь үндсэн бус үйл ажиллагааны орлого байгаа. Энэ төлбөрийн мөнгө нэмэгдээд 2024 оны ашиг ингэж өмнөх жилийнхээс өндөр гарсан юм.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: Номин реалтор ХХК-д Улсын их дэлгүүрийн барилгыг 1 м.кв-ыг нь ямар үнээр түрээслүүлдэг вэ?

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Түрээсийн төлбөрийн хэмжээг бид 2020-2024 оны хооронд 53%-иар өсгөж ажилласан байгаа. 2024 оны сүүлийн байдлаар нэг сарын түрээсийн төлбөр 818,300,000 төгрөгийн түрээстэй байсан. Энийг нийт талбайдаа харьцуулаад үзвэл 1 м.кв талбайн түрээсийн төлбөр НОАТ-тэй үнээр 30,466 төгрөг болж байгаа. Сүүлийн 2025 оны 3-р сарын хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар түрээсийн гэрээг Номин реалтор ХХК-тай шинэчлэн байгуулах зөвшөөрөл олгосон. Тус гэрээгээр түрээсийн үнийг 2 жил тутамд инфляци болон эдийн засгийн өсөлтийн дунджаар нэмэгдүүлэх нөхцөл оруулсан. Дээрх үнэ нэмэгдэх нөхцөлийн дагуу 2025 оны түрээсийн 1 м.кв талбайн нэг сарын төлбөрийг 32,601 төгрөгөөр буюу нэг сарын нийт түрээсийн үнийг 875,627,000 төгрөгөөр тогтоож гэрээ байгуулсан. 2024 оны инфляци 9%, эдийн засаг 5%-тай байгааг үндэслээд түрээсийн үнийг 2025 оны 04-р сарын 01-ний өдрөөс 7%-иар дахин нэмэгдүүлэхээр түрээслэгчтэй тохиролцож нэмэлт гэрээ байгуулан баталгаажуулсан.

Хурлын дарга Я.Наваан: За Номин реалтор ХХК-тай байгуулах түрээсийн гэрээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэд хэдэн удаа баталж өгч байсан. Компанийн урт хугацаанд үр ашигтай тогтвортой хөгжлийн үүднээс стратегийг нь баталж өгөхдөө бөөний түрээсийн загварыг сонгосон. Энэ нь маш цөөн хүн хүчний бүрэлдэхүүнтэйгээр барилгынхаа ашигтай, ашиггүй бүх талбайг бүхэлд нь түрээслүүлэх загвар юм. Ингэснээр тухайн талбай дээр түрээслэгч байгаа байхгүй нь хамаагүй, ашиггүй талбай дээрээ ч төлбөртэй байхаар, сар бүр тасалдалгүй төлбөрөө авч байх ийм давуу талтай учир энэ бөөний түрээсийн загварыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгож өгсөн. Нөгөө талаар түрээсийн талбайн дүүргэлтийн хэмжээ нь Утгаанбаатар хотын хамжээнд маш их муудаж байгаа гэсэн албан ёсны судалгааг Тэнхлэг зууч зэрэг компаниудаас гаргасныг өмнөх хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байсан. Миний санаж байгаагаар маш олон хотхон хорооллууд баригдаад үйлчилгээний талбайнууд нэмэгдсэн чинь түрээсийн талбайн дүүргэлт 87%-руу буурсан байгаа гэсэн статистик үзүүлэлт гарсан байсан. Ийм учраас Улсын их дэлгүүр ХК нь бөөний түрээсийн загвараар Номин реалтор ХХК-тай хамтарч ажиллаж байгаа үед талбай дүүргэлтийн асуудал байхгүй төлбөрөө 100 хувь авч байгаа. Мөн төлбөрөө ямар ч хоцрогдолгүй авч байгаа. Түрээслэгч орж гарахаас хамаараад хослон талбай гардаг ийм эрдэл байхгүй байгаа. Мөн Улсын их дэлгүүрийн барилгын онцлогоос хамаараад шатны хонгил, техникийн өрөө зэрэг ашиглалтгүй талбай их байдаг. Энэ ашиглалтгүй, түрээслэгддэггүй хэсгүүд нь нийт талбайн бараг 20 орчим хувийг эзэлдэг. Тэр

болгоноос бас түрээсийн төлбөр авч байгаа юм. Ер нь ямар ч барилга дээр тийм сул хэсгүүд гардаг.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: За би дахиад дүгнэлт юм уу санал ч юм уу нэг зүйл хэлнэ. Номин реалтор ХХК нь ийм их сул талбайтай барилгыг сарын 875 сая төгрөгөөр түрээсэлж байгаа мөртлөө өөрөө болохоор хэдэн тэрбумын ашиг олдог гээд байгаа шд. Цаашаагаа жижиг түрээслэгч нарт дамжуулан түрээслэхдээ тэндээс их ашиг олоод байна гэж харагдаж байгаа. Тийм учраас компани хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг тараах нэмэр болгох үүднээс 1 жил өөрсдөө түрээслүүлээд үзвэл яасан юм бэ. Шүүхийн шийдвэр дээрээс харж байхад Номин реалтор ХХК-ийн түрээсийн төлбөрөөс олдог ашиг нь их л том дүн харагдаж байсан. Заавал Номинд түрээслүүлэх ямар албатай юм бэ. Цаад утгаараа бол Номингийн хувьцаа эзэмшигч нар Улсын их дэлгүүрийн барилгыг түрээслэхгүй бол ногдол ашгаараа бусад хувьцаа эзэмшигч нартай ашгаа хуваах гээд байдаг, харин Номин реалтороор дамжуулж түрээслүүлэхээр ашгаа 100 хувь өөрсдөө авах гээд байдаг ийм ялгаатай зүйл харагдаж байгаа юм. Тэгээд нэг удаа ч гэсэн компани өөрсдөө түрээслүүлээд үзвэл яасан юм бэ гэсэн ийм санал байна.

Хурлын дарга Я.Наваан: Энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар миний мэдэхийн гурван ч удаа хэлэлцсэн байгаа. Тэгээд Улсын их дэлгүүрийн барилгын стратеги төлөвлөгөө, бизнес хөгжлийн төлөвлөгөө гэж юм байдаг. Үүгээр бол урт хугацаанд, үр ашигтай, улам үнэ цэнээ нэмэгдүүлсэн, Монгол улсын нүүр царай болсон ийм худалдааны төв байн гэдэг ийм бодлого байгаа юм. Энэ бодлогыг бид олон жил хамтдаа хэрэгжүүлээд явж байна. Олон том худалдааны төвүүд барьж байгуулагдсан боловч эхнээсээ нэлээдгүй хэд нь нэгдсэн том их дэлгүүрийн концепцыг хэрэгжүүлж чадаагүйгээсээ болоод дампуурсан, жижиглэж заралдсан тохиолдлууд байгаа. Тэгэхээр гийм нэхцэл байдалруу бид ороод дэлгүүрийнхээ үнэ цэнийг байхгүй болгоод, хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг үнэгүйдүүлэх нь эрсдэлтэй, буруу юм гэж ТУЗ ч үздэг, мөн хувьцаа эзэмшигчдийн хурал дээр ч энэ асуудлыг хэлэлцээд энэ их дэлгүүр гэсэн концепцоор Монголд үйл ажиллагаа явуулж байгаа, менежментийн, маркетингийн, худалдаа үйлчилгээний зэрэг энэ олон бодлогыг хэрэгжүүлж чадах энэ компанитай урт хугацаанд түншлээд явах нь зөв юм байна гэж үзээд өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлуудаар үзээд Номин реалтор компанитай түрээсийн гэрээ байгуулах эрхийг олгож байсан. Тэгээд мөн Номин реалтор ХХК нь Улсын их дэлгүүр компанитай олон талаар үр ашигтай хамтарч ажиллаж байгаа. Тухайлбал Номин реалтор ХХК нь тэр галын хохирлын үед маш богино хугацаанд өөрийн санхүүжилтээр Улсын их дэлгүүрийн барилгыг сэргээн засварлах, засаж сайжруулах ажлыг гүйцэтгэж өгсөн. Тухайн үед тэр барилгын засварын ажлын зардал дээр мэргэжлийн хөндлөнгийн аудитын компани оруулан дүгнүүлж байсан. Мөн компани галын хохиролтой холбоотой том өр төлбөрүүдийг үндсэндээ барагдуулчихлаа. Одоо бидэнд юу үлдээд байна вэ гэхээр Хаан банкнаас авсан 17 тэрбум төгрөгийн зээл байгаа. Энэ зээлийг юунд зарцуулсан бэ гэхээр 1-рт өмнөх жилүүдэд буюу 2005, 2006 онд хийгдсэн томоохон хөрөнгө оруулалтын зардлуудын зээлийн үлдэгдэл, сүүлд галын хохирлын улмаас барилгад хийгдсэн засвар, нөхөн сэргээлтийн ажлын зардалд зарцуулсан. Одоо энэ зээлээ бууруулж чадах юм бол компанийн үйл ажиллагаа нэлээд сайжраад явна гэж харж байгаа. Тэгээд энэ зээл дээр миний хэлэх гээд байгаа зүйл бол санхүүгийн нөхцөл байдал маань ингээд тогтворгүй байх үед Номин реалтор, Номин холдинг компаниуд 100 хувь өөрийн хөрөнгөөр батлан дааж, мөн хувьцаа эзэмшигч Баярсайхан өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан дааж Хаан банкнаас зээл авахуулсан. Бид арилжааны банкуудруу зээл авах хүсэлт тавьсан боловч батлан даалтгүйгээр зээл олгох газар олдохгүй байсан. Түүнчлэн энэ Хаан банкнаас авсан зээлийг хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр авч чадсан. Би буруу санаагүй бол жилийн 14.5%-ийн хүүтэй зээл авсан. Сард хуваавал бусад бизнесийн зээлүүдтэй харьцуулахад маш бага хүү юм. Гадуур бизнесийн зээлүүд 20% орчим хүүтэй байгаа. За гэх мэтчилэнгийн олон талын хамтын ажиллагааны хүрээнд Номин реалтор ХХК-тай хамтарч ажиллаад явж байгаа. ТУЗ-ийн үзэж байгаагаар одоо энэ стратегийг амжилттай үргэлжлүүлээд яваад зээлийн өр төлбөрөө бууруулчихвал цаашдаа улам илүү амжилттай ажиллаж, үнэ цэнэ нь өсөх юм байна. Тэгэхээр энэ түрээсийн загвар дээр тогтмал гээд Номин реалтор ХХК-тай түрээсийн гэрээ байгуулах асуудлыг сая өнгөрсөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бүс хуралд оруулан шийдвэрлүүлсэн байгаа.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: За дахиад нэг асуулт асууя. ТУЗ-ийн гишүүдтэй холбоотой өнгөрсөн 3 шатны шүүхийн шийдвэрээс харахад бол компани Номин реалтор ХХК-д зах зээлийн бус үнээр барилгаа түрээслүүлсэн гэдэг асуудал яригдсан. Одоо тэрнээс хойших энэ 2025 оны түрээсийн үнийг зах зээлийн үнэ гэж үзэх юм уу? Номин реалтор ХХК-иас цаашаа дамжуулан түрээслүүлж байгаа үнэ л зах зээлийн үнэ болохоос Улсын их дэлгүүрээс Номин реалторт түрээслүүлж байгаа энэ үнэ чинь зах зээлийн үнэ биш болчихоод байна. Энэ байдлаараа явбал дахиад шүүх дээр очиж төлбөрт унах асуудал үүсэхээр байна. Энэ дээр та бүхэн юу бодож байна вэ?

Хурлын дарга Я.Наваан: За сүүлийн жилүүдэд Улсын их дэлгүүрийн барилгыг бусдад түрээслүүлэх асуудлыг ТУЗ-өөр биш хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж шийдвэрлүүлэн батлуулж байгаа. Өөрөөр хэлбэл Номин реалтор ХХК-д бүхэлд нь түрээслүүлэх асуудлыг ТУЗ шийдээгүй хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлээд ажиллаад явж байгаа.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Улсын их дэлгүүр ХК маань орон тооны нийт хэдэн ажилтантай вэ?

Хурлын дарга Я.Наваан: Компани орон тооны 4 ажилтантай байгаа. Үүнд гүйцэтгэх захирал, ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар байдаг.

Хувьцаа эзэмшигч Ганболд: За компани маань 4 хэн ажилтантай. Улсын их дэлгүүрийн барилгыг уг нь гаднаас нь харахад их том барилга байгаад байдаг. За энэнээс гадна шат шатны шүүхийн шийдвэрээр Номин реалтор компанитай байгуулсан түрээсийн гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзээд байгаа. Энийг та бүхэн юу бодож байна вэ?

Хурлын дарга Я.Наваан: За тэр хуулийн зүйл заалт, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг би тайлбарлах ёсгүй байх. Тухайн үеийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан хүмүүсийн шийдвэр гаргалттай холбоотой маргаан явсан. Тухайн шүүхийн шийдвэрийг бид биелүүлээд явж байна. Төлбөр мөнгийг нь 1 жилийн дотор бүрэн төлүүлээд компанийн орлогод хүлээн авч ажилласан.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Би ойлгохдоо бол хүчин төгөлдөр бус хэлцэл гэж сонирхлын зөрчилтэй хэлцэл буюу Номингийн хувьцаа эзэмшигч нар Улсын их дэлгүүрийг өөрийнхөө хамаарал бүхий компанитай хэлцэл хийлгэсэн асуудлыг хэлээд байна гэж ойлгож байна. Энэ хэлцэл хийж байгаа улсууд нь Улсын их дэлгүүрийн дийлэнх хувьцааг эзэмшиж байгаа хүмүүс байгаа. Тэгэхээр ийм хүчин төгөлдөр бус хэлцэл хийгээд байж болохгүй гэж үзэж байна. За мөн өнгөрсөн 2024 онд хэдэн төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөсөн бэ?

Хурлын дарга Я.Наваан: ТУЗ-оос баталсан Бизнес төлөвлөгөөгөөр бол компани 2024 онд 3.4 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөсөн. Тэгээд төлөвлөгөө 93 хувьтай биелсэн. Түрүүн дурдсан шүүхийн шийдвэрийн дагуу төлөгдсөн 2.4 тэрбум төгрөг орж ирээд энэ төлөвлөгөө биелэгдэж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Өнгөрсөн жилийн тайлан дээр бол 43 сая төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөөд 108 сая төгрөгийн ашигтай ажиллаад 220%-ийн биелэлттэй ажилласан гэж байсан. За энэнээс гадна өөр бас нэг зүйл байна. Өнгөрсөн хугацаанд олон шатны шүүхээр явж байхад манай 4 хон ажилтантай Улсын их дэлгүүр маань үйл ажиллагааныхаа зардлыг өөрсдөө даадаг ийм асуудал байгаад байна. Сая энэ тайлангаас харахал 11 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан гэхихээд 7.7 тэрбум нь үйл ажиллагааны зардал гэж байгаа. Яагаад тэр бүхэлд нь түрээслэж байгаа компани үйл ажиллагааны зардлыг хариуцахгүй байна вэ? Яагаад 4 хон ажилтантай компани 7.7 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргасан байгаа вэ?

Хурлын дарга Я.Наваан: Үйл ажиллагааны зардалд энэ барилгын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой дулаан, цахилгаан зэрэг ашиглалтын зардлууд нэлээд өндөр хувийг эзэлж байгаа. Барилгаа засаж сайжруулж байх ёстой. Барилга маань бас нэлээд хуучирсан 60 хэдэн оны барилга гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Тэгээд эдгээрийг ажиллуулахын тулд ашиглалтын зардлыг нэлээд өндөр гаргахаас өөр аргагүй болж байна. Тэгэхээр эдгээр зардлууд үйл ажиллагааны зардлын дийлэнх дүнг эзэлчихэж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Ашиглалтын зардлуудыг задлаад танилцуулж өгөөч. Мөн 7.7 тэрбум төгрөгийг зарлагдаж байгаа байгууллага 4 хөн ажилтантай. Энэ 4 ажилтан тэр их үйл ажиллагааны хаана нь хүрч ажиллаж байгаан. Компани ядаж л ХАБЭА-н ажилтантай байх ёстой. Тэгвэл тэр ХАБЭА-н үүргийг хэн хүлээх гэж байгаа вэ. Улсын их дэлгүүр компани хариуцах уу эсвэл Номин реалтор хариуцах уу. Тэгэхээр энэ асуудал жаахан эргэлзээтэй байна.

Хурлын дарга Я.Наваан: За ашиглалтын зардлын задаргааг тайлбарлаж өгье. Үйл ажиллагааны зардал болох 7.7 тэрбум төгрөгийн 45.7%-ийг цэвэр, бохир ус, цахилгаан, дулаан зэрэг ашиглалтын зардал эзэлж байгаа. 27.4%-ийг зээлийн хүүгийн зардал эзэлж байгаа. 2.2 тэрбум орчим төгрөгийг зээлийн хүүнд өгч байгаа. Энэ нь түрүүн танилцуулсан Хаан банкнаас авсан 17 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн зардал юм.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: Зөвхөн зээлийн хүүг төлж байгаа юм уу? Үндсэн зээлээс төлж байгаа юу?

Хурлын дарга Я.Наваан: Одоогоор зөвхөн зээлийн хүүг төлж байгаа. Үндсэн зээлийг 2025 оны 8 сараас эхэлж төлөөд явна. Бангтай байгуулсан зээлийн гэрээгээр ийм нөхцөлтэй байгаа.

Хувьцаа эзэмшигч Ганболд: За дараагийн асуудал бол 17 тэрбум төгрөгийн зээлийн дүн өмнөх жил яг энүүгээрээ байж л байсан, одоо ч байж л байна. Жилийн 14 хувийн хүүтэй урт хугацааны зээл байгаад байна. Энэ зээлийн хүүнд жилд хэдэн төгрөг төлж явах вэ? Мөн энэ 17 тэрбумын зээл дээр галын хохирлын улмаас бусдад төлөх өглөгийн үлдэгдэл 800 сая төгрөгийг нэмээд бараг 18 тэрбум төгрөг болж байна. Энэ 18 тэрбум төгрөгийн ор толборийг одоо тэгээд хэзээ төлж барах вэ? Хэзээ компани ашигтай болж эхлэх вэ? Энэ мөнгийг төлж дуусахаас нааш ногдол ашиг хуваарилах боломжгүй байхаар харагдаж байна. Энэ асуудал цаашаа хэдэн жил үргэлжлэх вэ. Яагаад энэ 17 тэрбум төгрөгийн зээлийг хүүтэй нь хугасалахгүй ингээд хэвээрээ байгаад байдаг юм бэ? Өнгөрсөн жил орж ирсэн тэр 3 арвны хэдэн тэрбум төгрөгийг зээлрүүгээ хийгээд багасгахгүй яасан юм бэ.

Хурлын дарга Я.Наваан: Шүүхийн шийдвэрээр бид төлбөр төлөх үүрэгтэй болсон учраас шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх шаардлагатай болсон. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй бол шийдвэр гүйцэтгэх байгууллагаас компанийн дансуудыг битүүмжлээд хүчээр бүх орлогыг нь авах асуудал үүсэх гээд байсан. Дэнсав битүүмжлүүлчихвэл бүх үйл ажиллагаа саатах гээд байсан. Иймд шүүхийн шийдвэрийг биелүүлж төлөхөөс аргагүй болсон. Бид шүүхийн шийдвэрийн дагуу бусдад төлөх ёстой өглөгөө нэлээд сайн багасгасан. Одоо харин зээлийн хүүгийн зардал манай компанийн гол ачаалал болж байна. За түрүүн хэлсэнчлэн зээлийн хүүгийн зардал нь үйл ажиллагааны зардлын 27.4% байна. Мөн дэлгүүрийн барилга маань хуучирсан учраас өөрөө элэгдээд байгаа. Тэр нь 17.6%-ийг эзэлж байна. Тэгээд цаана нь ашиглалтын зардлууд яаж өсөж байгаа билээ.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Өөр нэг юм байна. Энэ санхүүгийн тайлан дээр дансны авлага гээд 380 сая төгрөг байна. Энэ авлага урд нь байгаагүй хаанаас гараад ирэв? Авлага барагдуулах талаар гүйцэтгэх захирал юу хийж байгаа вэ?

Хурлын дарга Я.Наваан: За энэ авлага нь бол барилгын засварын ажил гүйцэтгэсэн компаниудад ажлын хөлсийг нь НӨАТ-тэй үнээр төлөөд явсан. Гэтэл барилгыг

капиталжуулчихсан учраас НӨАТ нь барилга алэгдэх хугацаанд хасагдаж явдаг ийм хуулийн зохицуулалттай. Тэгэхээр тайлан дээр тэр нь улсаас авлагатай юм шиг харагдаад байгаа юм. Харин бараа, үйлчилгээ байсан бол НӨАТ-ыг дор дор нь хасаад явах байсан.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Мөн дансны өглөг 256 сая төгрөг байсан чинь одоо 926 сая болчихсон байна. Бараг 700 сая төгрөгөөр дансны өглөг ихэссэн байна. Энэ ямар учиртай вэ?

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Энэ нь мөн түрүүн танилцуулсан галын хохиролтой холбоотой шүүхийн шийдвэрээр тогтоосон өглөг юм.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Шүүхийн шийдвэртэй холбоотой дансны оглог 2023 оны санхүүгийн тайланд суугаад явж байх ёстой биз дээ.

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Шүүхийн шийдвэр 2023 оны эцсээр албажиж гараад ирсэн. Энэний дагуу бид аудитын дүгнэлтэд үндэслэлд 2024 оны 1-р улирлын тайланд оруулсан учраас дансны өглөгөөр бичигдаж орсон юм.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Хаан банканд сар бүр төлж байгаа зээлийн хүү 2.4 тэрбум төгрөг гэсэн мөртлөө санхүүгийн тайлан дээр хүүгийн өглөг 189 сая төгрөг гээд дахиад өөр дүн байгаад байна. Энэ ямар учиртай вэ?

Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар: Зардалд бол тооцогдсон хүү суугаад явж байгаа. Тэндээсээ зээлийн хүүг графикийн дагуу төлөөд явахаар тодорхой хугацаагаар тасалбар болоод тайланд тусгагдаад явж байгаа юм. Тэгэхээр тэр тасалбар болгон төлөөд үлдэж байгаа хүү буюу төлөгдоогүй хэсэг нь 189 сая болж тусгагдсан юм.

Хувьцаа эзэмшигч Ганболд: За тоо цифртэй холбоотой юм асуугаад байвал зөндөө л юм байна. Тэрнээс гадна Дашзэвэг докторын хэлсэнчлэн түрээслэгчийг нээлттэй сонгон шалгаруулж түрээслэгчээ сонгож болдоггүй юм уу? Түрүүн хариултыг сонссон ч гэсэн дахиад асуумаар байна. Заавал Номин гэлтгүй И март ч юм уу өөр газар түрээслүүлж болно ш дээ. Чадалтай компаниуд байна шд.

Хурлын дарга Я.Наваан: Түрээсийн асуудлыг нэгэнт хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэгдсэн учраас ТУЗ болон гүйцэтгэх захирлын зүгээс шийдвэрийг нь хэрэгжүүлээд л явж байна.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Харин тэр хувьцаа эзэмшигчдийн шийдвэр чинь өөрөө хүчин төгөлдөр биш болоод байгаа юм бишүү?

Хурлын дарга Я.Наваан: За та тэгж үзэж байгаа юм байна. Гэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг би хүчинтэй хүчингүй гэж тодорхойлох боломжгүй. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон, санал өгсөн хүмүүсийн хувьцааны саналын эрхийн олонхоор шийдвэрлэгдсэн асуудал.

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг: Одоо Номинд хамааралтай хувьцаа эзэмшигч нар хувьцааны хэдэн хувийг эзэмшиж байгаа вэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Номин холдинг ХХК-д хамааралтай хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны хувь 69.8% орчим байгаа.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Би анх удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байна. 1996 оноос хойш танай компанийн хувьцааны ногдол ашиг гэж 1300 төгрөг л авсан. Та хэдийн ярьж байгаагаар бол 2020 онд дэлгүүрийн барилга шатаад баахан ор тавиад ашиггүй

ажиллаад байгаа юм шиг ярьж байна. Тэрнээс өмнө ногдол ашиг өгдөггүй байсан юм уу? Хуваарилсан юм байна уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: За би энэ асуудал дээр товчхон хариулт өгье. Улсын их дэлгүүр ХК нь 2000 онд хувьчлагдсан компани. Тэрнээс хойш 2002, 2008, 2012 онуудад ногдол ашиг хуваарилж байсан. Гэхдээ жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааных нь тоо ширхэгээс хамаарч хүмүүст бага хэмжээний ашиг хуваарилагдсан байх. Компани маань 43 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй учраас хуваарилагдсан ногдол ашиг нэг хүнд бага хэмжээгээр ногддог асуудал байгаа. Нийт хувьцаа эзэмшигчдийн дийлэнх нь 149 ширхэг хувьцаатай буюу өмч хувьчлалын цэнхэр, ягаан тасалбараар хувьцаа эзэмшигч болоон хүмүүс байдаг. Компани нийт 36 807,850 ширхэг хувьцаа гаргасан бөгөөд жишээ нь 2 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр гаргалаа гэхэд нэгж хувьцаанд 54 төгрөг ногдож байгаа. Энэ дүнгээр бол жишээ нь 149 ширхэг хувьцаатай хүнд 8 мянган төгрөг ногдоно гэсэн үг. Хувьцаа эзэмшигчид компаниас хуваарилсан ногдол ашгаас эзэмшиж байгаа хувьцааныхаа тоо хэмжээнд хувь тэнцүүлэн авдаг.

Хурлын дарга Я.Наваан: Хөрөнгийн зах зээлд оролцож байгаа хүмүүс маань хувьцааны ногдол ашиг эсвэл хувьцааны үнэ цэнийн өсөлтөөс үр ашиг хүртэх боломжтой байдаг. Тэр утгаараа манай компанийн хувьцааны үнэ бол биржийн арилжаанд харьцангуй тогтвортой өсөөд явж байгаа. Өнөөдрийн байдлаар 1 ширхэг хувьцаа 3400 орчим төгрөг байх шиг байна. Тэгэхээр анх хувьцаа авч байсан үеэс бодоход энэ бол хэд дахин өсчихсөн үнэлгээ байгаа. Компани бол урт хугацааны үнэ цэнээ нэмэгдүүлэх стратегитай яваад байгаа. Тэгээд ногдол ашиг тараах нөхцөл байдал бол хувьцаа эзэмшигчид маань маш олон, тархмал байгаа учраас хувьцааныхаа үнэ цэнийг нэмэгдүүлэх нь хувьцаа эзэмшигчдэд илүү хэрэгтэй юм болов уу гэж харж байгаа.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Хариултыг нь сонслоо. Улсын их дэлгүүр ногдол ашгаас өгдөггүй юм байна. Гэхдээ сонирхол нь жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааг авах сонирхолтой юм байна гэж ойлгож байна. Компанийн санхүүгийн тайланг ерөнхийд нь харлаа. Энэ тайлангаас харахад ямар ч утга алга. Сарын 875 сая төгрөгийн түрээсийн орлого авдаг, жилд 10.5 тэрбум төгрөгийн орлого олдог. Эндээс гарч байгаа зардал нь маш өндөр байна. Тэгсэн мөртлөө 4 хөн ажилтантай гэж байгаа. Тиймээс компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дахиж аудитын шалгалт оруулмаар байна.

Хурлын дарга Я.Наваан: Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-ийн зүгээс хөндлөнгийн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулаад санхүүгийн тайланд аудит хийлгэдэг.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Хувьцаа эзэмшигч аудитын шалгалт оруулах санал гаргах эрхтэй гэж бодож байна. Тэрнээс гадна ТУЗ-д байгаа энэ 8 гишүүнд яагаад Номингоос заавал 6 хүн нь орох ёстой юм. Яагаад хараат бус гишүүн нь заавал 3 хүн байх ёстой юм. 50, 50 хувь байж болохгүй юу? Энэ олон хувьцаа эзэмшигч нарын төлөөллөөс ТУЗ-д 50 хувь нь байх ёстой гэж үзэж байна. Тэгж байж ядаж зөв шийдвэр гарах ёстой.

Хурлын дарга Я.Наваан: Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-ийн нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх ёстой, бусад гишүүд нь ердийн гишүүн байж болох ийм зохицуулалттай байгаа. Одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас кумулятив аргаар сонгож баталгаажуулж өгсөн. Түүнээс гадна компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийн саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд өөрийн толооний хүнийг нэр дэвшүүлэх эрхтэй байдаг. Үүний дагуу Номин холдинг ХХК-д хамааралтай ТУЗ-ийн ердийн 6 гишүүнийг тус компанид хамааралтай Улсын их дэлгүүр ХК-ийн 5-аас дээш хувьтай хувьцаа эзэмшигчийн зүгээс хуульд заасан эрхийнхээ дагуу нэр дэвшүүлсэн.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Тэгвэл тэр Компанийн хуулиндаа өөрчлөлт оруул л даа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг ТУЗ батлаад нийтэд нээлттэй зарлан мэдээлсэн үед ТУЗ-ийн гишүүнд нэрээ дэвшүүлэх эрх нээлттэй байгаа. Хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн гишүүнд нэрээ дэвшүүлэх тохиолдол гардаггүй. Өнгөрсөн жил бол Ганбаяр гэж хүн хараат бус гишүүнд оорийгөө нэр дэвшүүлж байсан. Нэр дэвшүүлсэн хүнийг л хувьцаа эзэмшигчдийн хуралд өргөн барих ёстой байдаг.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Энэ хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн гишүүд өөрсдөө оролцоод жилийн хугацаанд ямар шийдвэр гаргасан талаараа танилцуулж болдоггүй юм уу. Ялангуяа хараат бус гишүүд заавал байх ёстой. Хараат бус гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн өмнөөс дугарах ёстой хүмүүс гэж ойлгож байна. Тэрнээс гадна өмнөх жилд компани ашигтай ажилласан гэж тайланд байна. Тэгэхээр энэ ашгаас ногдол ашиг хуваарилах ёстой гэж үзэж байна. Гэтэл ТУЗ-ийн гишүүд хуралдаад л ногдол ашиг хуваарилахгүй гээд шийдчихдэг. Яагаад энэ жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдэдээ хувьцааны мөнгө гээд хэдэн төгрөг өгчихөж болоогүй юм. Номин том ш дээ. Энд тэндгүй Номин байдаг. Би энэ хэлэлцэж байгаа асуудлуудыг бүгдийг нь хүлээн зөвшөөрөхгүй.

Хурлын дарга Я.Наваан: За таны саналуудыг сонслоо. Хараат бус гишүүдийн оролцоог хангах асуудлыг анхааръя. Аудитын шалгалт дахин оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийнх нь дагуу шийдэж болох байх. Ногдол ашгийн асуудал дээр таны хэлсэн санал дээр нэмж тайлбар хийх шаардлагатай гэж бодож байна. Компани 2024 онд 3.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Бид тодорхой хэмжээгээр ногдол ашиг хуваарилах бодлого барьж ажиллаж болж байгаа юм. Гэтэл Компанийн тухай хуулиар ногдол ашиг хуваарилахад тавигдах шаардлагуудыг хуульчилсан байдаг. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд ногдол ашиг тараах тохиолдолд ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх, ногдол ашиг төлсний дараа компанийн оорийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байх гэсэн шаардлагууд тавигддаг. Гэтэл компани маань өнгөрсөн олон жилийн хугацаанд дэлгүүрийн барилгаа засаж сайжруулах ажлуудыг ч зөндөө хийсэн, мөн бидэнд тааварлах боломжгүй гэнэтийн галын аюулын улмаас хохирол учирч, дэлгүүрийн барилгаа сэргээн засварлах шаардлага тулгарсан. Эдгээр нөхцөл байдалд компаниас нэлээдгүй хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулах шаардлагууд тулгарч тухай бүр банк, санхүүгийн байгууллагаас зээл авч ажиллаж байсан. Одоо ч зээлийн дарамтаас гараагүй байна. Хэдийгээр компани цэвэр ашигтай ажилласан боловч дээр дурдсан хуулийн шаардлагыг хангаж чадахгүй байгаагийн улмаас ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаад байгаа юм шүү. Бид бүх үйл ажиллагаагаа Компанийн тухай хууль болон бусад хууль, дүрэм, журамд нийцүүлээд явж байна.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: ТУЗ-ийн 9 хүн ярилцаад ногдол ашиг хуваарилахгүй гэсэн энэ тогтоолыг гаргачихсан юм уу? Ийм зүйл байж болдог юм уу?

Хурлын дарга Я.Наваан: Компанийн тухай хуульд зааснаар Төгөөгөн удирдах зөвлөл компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг гаргадаг. Энэ дагуу шийдвэрээ гаргасан байгаа.

Хувьцаа эзэмшигч Хархүрэн: Би Улсын их дэлгүүрт хувьцаатай гэдгээ саяхан мэдсэн. Бумбат алтай брокерын компаниас мэдсэн. Манай гэр бүлийн хүн бид 2 нийлээд 200 аад ширхэг хувьцаатай. Тэгээд брокерын компаниас хувьцааны ногдол ашгаа асуухаар компани ашиггүй ажиллаж байгаа. Таны дансанд 200 төгрөг байна гэж хэлээд л явуулдаг. Миний хувьд бас анх удаа хуралд сууж үзэж байна. Бумбат алтай компани надад 20-нд хувьцаа эзэмшигчдийн хурал болох гэж баягаа гэж мэдээлэл өгөөд нааш нь явуулсан. Хуулийн болон санхүүгийн мэргэжлийн хүмүүсээс том компаниуд өчнөөн олон тэрбумын ашигтай ажилладаг мөртлөө ашгаа дардаг гэж сонссон. Би энэ санхүүгийн тайлан тоонуудыг хараад сайн ойлгохгүй. Би зүгээр үйлдвэрийн ажилчин байсан хүн. Сая хуралд танилцуулснаас сонсоход галын аюул тулгараад их хэмжээний өр зээл тавьсны улмаас ногдол ашиг өгөх боломжгүй байна гэж

тайлбарлаж байна. Энэ мэтчилэнгээр хувьцаа эзэмшигчдээ зөнд хаяж байна. Өнөөдөр компаниуд хүмүүсийг цалингүй ажиллуулна гэж байхгүй. Тэрэнтэй адилхан хувьцаа эзэмшигч бид нарыг зүгээр гадна хаячихсан, 2-рт бид нарын нас явж байна. Би 70 хүрч байна. Маргааш би бүрхэн болчиж магадгүй учраас мөнгө авсан ч яаалаа байсан ч яаалаа. Ядаж үр хүүхдүүдэд минь үлдээл цаашдаа яаж юм бол гэж бодож байна. Та нар өртэй ч байсан ашиггүй ч байсан хувьцаа эзэмшигчиддээ ногдох мөнгийг нь өгөөрэй. Энэ их тоо тооцоог чинь хараад би бол мэдэхгүй байна. Ингээд олон шалтаг хэлээд байвал би юу ч ойлгохгүй юм байна.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Би дахиад нэг зүйл асууя. Түрүүн хурлын ирц 53% гэж танилцуулсан. Гэтэл энд 20 гаруйхан хүн сууж байна. Юуг үндэслэж хурлын ирц ийм болчихов? Мөн би өмнөх үг хэлсэн хүмүүстэй санал нэг байна. Бид Номинд түрээслүүлээд ашиг олдоггүй юм байна. Номингийн сонирхол нь бол бид нарын хувьцааг авах сонирхолтой юм байна. Би Номинд хувьцаагаа өгөхгүй. Харин Номинг сольно. Номинд түрээслүүлэхгүй өөр газар түрээслүүлнэ. Өөр ашигтай үйл ажиллагаа явуулж байгаа тийм газар түрээслүүлэх сонирхолтой байна. Тэгэхээс бид нар хувьцаагаа зарахгүй. Та бүгд ч гэсэн хувьцаагаа битгий зараарай. Номин бол бид нарын хувьцааг авч Улсын их дэлгүүрийг өөрийн болгох гэж байгаа.

Хурлын дарга Я.Наваан: Компанийн тухай хуулийн 68.1-д зааснаар компанийн нийт хувьцааны 50-аас дээш хувийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцооноор хурал хүчин төгөлдөр болдог. Хүний тоогоор биш хувьцааны саналын эрхийн тоогоор ирц болон шийдвэр хүчинтэй болдог. Өнөөдрийн хуралд нийт хувьцааны 53%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцож байгаа учраас хурлын ирц бүрдсэн. Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааных нь тоо ширхэгээр саналын эрх нь тоологддог. Харин хүний тоогоор биш юм. За та бүхний хэлсэн саналуудыг ойлголоо. Бид компанийг үр ашигтай ажиллуулах гээд хичээгээд ажиллаж байгаа. Та бүхэн ингээд хуралдаа оролцоод компанийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалтай танилцаад санал хүсэлтээ хэлээд явж байгаа нь талархууштай байна. Бид бас юуны төлөө ингээд хичээгээд ажиллаад байгаа нь гэдгээ бас дутуу ойлгуулдаг юм шиг байна. Энэ компанийг урт хугацаанд тогтвортой ажиллуулаад, өмнө нь хэдэн төгрөг байсан хувьцааны ханш одоо 3500 хавьцаа болсон байгааг та бүхэн бас нэг талаасаа бодолцоосой гэж хүсэж байна. Тэгээд цаашид ногдол ашиг хуваарилахын төлөө чармайн ажиллая.

Хувьцаа эзэмшигч Алтанцэцэг: Энэ хувьцаа эзэмшигчдийн хурал гэж та нар хийж байна. Би бас анх удаа оролцож байна. 1995 онд би хувьцаагаа өгсөн. Тэгээд одоо энэ Улсын их дэлгүүрийн хувьцаа эзэмшигчдийн хурал болох гэж байна гэдгийг телевизээр хэзээ ч сонсоогүй. Би Хөрөнгийн бирж дээр очиж уулзсан. Сүүлийн 3 хан жил Улсын их дэлгүүр хурлаа хийж байгаа. Тэрнээс өмнө хийгээгүй та хуралд нь очиж суудаггүй юм уу гэж хэлсэн. Энэ компани 2000 онд хувьчлагдсан гэж байна. Тэрнээ хойш надад ногдол ашиг гэж 710 төгрөг л орсон байсан. Энэ яаж ч бодсон гэсэн 25 жилийн дотор хувьцааны мөнгө гэж 710 төгрөг орох ёсгүй байх. Энийг ойлгохгүй байна. Улсын их дэлгүүр шиг орлого ихтэй газар байхгүй. Тийм учраас танайх ерөөсөө хувьцааны мөнгө өгдөггүй газар байна. 2-рт өнөөдрийн хуралд 20 орчим хүн сууж байна гэтэл хурлын ирц 50 хувь гэж байна. Тэгэхээр нь энэ компанид 30-аадхан хүн л байдаг юм уу гэж би ойлгож байна. Гэтэл сая танилцуулахдаа 43 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй 36 сая ширхэг хувьцаатай гэж байна. Энэ хүмүүсээ яагаад хуралдаа оруулдаггүй юм бэ. Хүмүүст хурлын талаар мэдээлэл муу хүргэж байна. Хувьцаа эзэмшигчид ч гэсэн шаардлагаа муу тавьж байна. Санал бодлоо хэлэх хүн байхгүй байна. Хүмүүс хувьцаатай гэдгээ ч мэдэхгүй явж байгаа. Тийм учраас танайх телевизээр Улсын их дэлгүүрт хувьцаагаа оруулсан хүмүүсийг нэр устай нь хэлээд хувьцаа ирж ав гэж хэл. Та нар хүмүүсийн эзэнгүй хувьцааг ингээд байлгаад байж болохгүй. Мэдэхгүй хүн зондоо байна. Эзэмшиж байгаа хувьцаа тоогоор биш хүнийх нь тоогоор хурлаа зохион байгуулах хэрэгтэй. Би танайхаас юу нэхэх вэ гэхээр өгсөн хувьцааныхаа 25 жилийн ногдол ашгийг авна их ч бай бага ч бай. Яагаад заавал компанийн олсон ашгаас компанийн өр төлөгдөөд харин ард түмэн хоосон хоцорч байх ёстой юм.

Хурлын дарга Я.Наваан: За таны саналыг ойлголоо. Хуралд олон хүнийг хамруулж байх ёстой гэдэг дээр санал нэг байна. Энэ дээр анхаарч ажиллая. Бидний зүгээс хурлын зар хүргэх журамд заасны дагуу сонин хэвлэл, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хурлын зараа хүргэж байгаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Хурал зохион байгуулагчдын зүгээс хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталж өгсөн төсвийн хүрээнд хурлаа зохион байгуулах шаардлагатай болдог. Тэгэхээр бид боломждоо тааруулаад одор тутмын сонин хэвлэл, ТВ-үүдийн үгэн зараар хурлын зараа хүргэж байгаа. Мөн дээрээс нь олон хүнд хүргэх үүднээс Фэйсбүүк, сошиал сувгийг ч мөн ашиглаж байна. Тухайлбал Фэйсбүүк дэх Улсын их дэлгүүрийн жижиг хувьцаа эзэмшигчдийн группийн админд хандаад хурлын зар болон танилцуулга материалыг нийтлэж өгөөч гэж хүсэлт гаргаад нийтлүүлсэн. Тухайн групп нь 2 мянга гаруй гишүүнтэй групп байдаг. Одоо бодит байдал дээр сонин уншдаг, ТВ-ээр мэдээ үзээд суудаг хүн ховордсон учраас сошиал сувгууд нь илүү олон хүнд хүрч байгаа. Жижиг хувьцаа эзэмшигчдийн группт нийтлүүлсэн хурлын зарыг олон хүн үзсэн, харсан байсан. Тэгсэн мөртлөө өөрсдөө хуралдаа идэвхигүй оролцож байна. Надруу хандаад утаснаар хурлын материалтай танилцъя гэсэн хүмүүст и-мэйлээр нь хурлын танилцуулга материалыг мөн явуулж өгч байсан. Зарим хувьцаа эзэмшигч нар өөрсдөө идэвхитэй хандаад надаас танилцуулга материал, мэдээлэл аваад явдаг ийм хүмүүс бас байгаа. Мөн брокерын 30 гаруй компаниудад хурлын танилцуулга материалаа цахим хэлбэрээр хүргүүлсэн. Эдгээр брокерын компаниуд бас үйлчилгээ авч буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх асуудал хангалтгүй байна. Нийт 43 мянга гаруй хувьцаа эзэмшигчдэд бид хүн тус бүрт хурлын талаар мэдээлэл, танилцуулгыг хүргүүлэх боломжгүй. Хувьцаа эзэмшигчдийн утасны дугаар, хаяг, бүртгэл ч бидэнд байдалгүй. Бид өөрсдөө хувьцаа эзэмшигчдийнхээ бүртгэл, судалгааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс татаж авдаг.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Та нар өөрсдөө бас Фэйсбүүк дээр Улсын их дэлгүүрийн хаяг, групп нээгээд мэдээллээ хүргээд явж болно ш дээ.

Хувьцаа эзэмшигч Алтанцэцэг: Би дахиад нэг юм асууя. Компанийн ашгаас ногдол ашиг олгохгүй гэсэн шийдвэрийг яагаад ТУЗ-ийн энэ хэдэн хүмүүс гаргадаг юм бэ? Энэ хүмүүс ийм архтэй юм уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Компанийн тухай хуулийн 46-р зүйл болон 78-р зүйлд тухайн жилийн компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргахаар заасан байдаг. Үүний дагуу ТУЗ шийдвэрээ гаргаад явсан байгаа. Ингэж шийдвэр гаргахдаа Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах шаардлага хангагдсан эсэхийг харгалзан үзэж шийдвэрлэдэг.

Хувьцаа эзэмшигч Болормаа: Би 149 ширхэг хувьцаатай. Тэгээд танайх энэ ногдол ашиг өгөхгүй байгаа нь ямар учиртайг би ердөө ойлгохгүй байна. 2-рт өмнө нь өгсөн ногдол ашгуудыг би ердөө аваагүй. Төрийгээ нөхөж авмаар байна. Мөн 98 хэдэн оны ягаан цэнхэр тасалбарын гэрчилгээ танайд байна уу. Тэр гэрчилгээгээ нэг бол бид буцааж авч өөр газар өгч ашигламаар байна. Миний хувьд саяхан Улсын их дэлгүүрт хувьцаагаа өгснөө мэдсэн. Энэ миний хувьцаа яагаад танайд очсоныг би бас гайхаад байна. Тараасан үеийн ногдол ашгаа нөхөж авмаар байна. Минийх ягаан, цэнхэр тасалбар 2-уугаа байх ёстой.

Хурлын дарга Я.Наваан: Манай компани хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй хэдэн компанийн нэг болчихоод байгаа. Түүхийг нь судлаад үзэхэд тухайн үед Төрийн өмчийн хороон дээр аль компанид өгөх нь тодорхойгүй нэлээд тасалбарууд үлдсэн юм шиг байгаа юм. Тэр үлдсэн тасалбаруудыг Улсын их дэлгүүр ХК-руу өгчихсөн тийм асуудал үүссэн байгаа юм. Төрийн өмчийн хороо нэг ийм зохицуулалт хийснээс болоод хүмүүс өөрсдөө хаана хувьцаа эзэмшиж байгаагаа мэдэхгүй яваад байгаа ийм асуудал байгаа. Одоо бол уг нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэл байж байгаа.

Тэндээс очоод өөрсдийнхөө хаана аль компанид хувьцаа эзэмшдэг гэдгээ мэдээд явах боломжтой болчихсон. Тар хувьцаа эзэмшигчийн бүртгэл чинь өөрөө таныг хувьцаа эзэмшигч мөн гэдгийг баталж байгаа батламж болж байгаа юм. Энэ эзэмшиж байгаа хувьцаагаа та брокерын компаниараа дамжуулаад зарах юм уу шилжүүлэх юм уу хөдөлгөөнд оруулах эрх нь танд нээлттэй байгаа. Компаниас ногдол ашиг тараах бол Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд мөнгөө байршуулдаг байгаа. Тэгээд тухайн байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн дансанд хуваарилах ажлыг хийдэг. Тийм болохор өмнө нь хуваарилж байсан ногдол ашгийг та аваагүй бол тухайн хувьцааны бүртгэлийн байгууллагад хандах нь зүйтэй. Компани бол мөнгөө тийш нь байршуулчихсан.

Хувьцаа эзэмшигч Алтанцэцэг: Над шиг Улсын их дэлгүүрт хувьцаатай гэдгээ мэдэхгүй явж байгаа хүмүүс зөндөө байна. Тийм учраас та нар телевиз радиогоор ийм ийм хүмүүс манай компанид тэдэн ширхэг хувьцаа эзэмшиж байна гэдгийг зарлаж өг.

Хурлын дарга Я.Наваан: Бид олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр тэгж хүний нэр, эзэмшиж байгаа хувьцааных нь талаар дурдаад хувьцаа эзэмшигчийн хувийн нууцад халдаж нэвтрүүлэг зар явуулж болохгүй. Энэ нь өөрөө Хувь хүний нууцын тухай хууль зөрчсөн үйлдэл болно. Хүмүүс өөрсдөө холбогдох газруудаас нь асууж сураглаад хаана хэдэн ширхэг хувьцаа эзэмшиж байгаагаа мэдэх ёстой. Бидэнд хүний хувийн мэдээллийг тараах эрх байхгүй.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН ХОЁРДУГААР АСУУДАЛ:

За 1-р асуудалтай холбоотой санал хүсэлт, асуултын үе шат дууслаа. Ингээд хурлаар хэлэлцэх 2 дахь асуудал буюу 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг төсвийг батлах асуудалдаа оръё. Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч та бүхнийг энэ танилцуулж буй зардлыг төсвийг баталж өгөөчээ гэж хүсье гээд дараах төсвийг танилцуулав.

№	Төрөл	Төсөв /Мян.төг/
1	ТУЗөвлөлийн ердийн гишүүний цалин урамшуулал	24,000.00
2	ТУЗөвлөлийн хараат бус гишүүний цалин урамшуулал	18,000.00
3	ТУЗөвлөлийн хурал зохион байгуулах төсөв	800.00
4	Нийт төсөв	42,800.00

Зардлын нийт төсвийг 42.8 сая төгрөгөөр төлөвлөж байна. Энэ нь бол 2025 оны 4-р сараас эхлээд ирэх оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх 12 сарын хугацааны зардлын төсөв байгаа. Үүнд ТУЗ-ийн хараат бус 3 гишүүнд хурлын цалин 18 сая төгрөг, ТУЗ-ийн ердийн 6 гишүүнд хурлын цалин 24 сая төгрөг, харин хурал зохион байгуулах зардалд 800 мянган төгрөг төсөвлөсөн байгаа. ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахад бас тодорхой хэмжээний зардал гардаг. За энэ зардлыг хувьцаа эзэмшигч та бүхэнд хурлын эцэст саналын хуудсаар санал өгөхдөө шийдвэрлэж огох ёстой байгаа.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН ГУРАВДУГААР АСУУДАЛ:

Хурлын дарга Я.Наваан: За дараагийн бидний хэлэлцэх асуудал бол ТУЗ-ийн гишүүдийг нөхөн болон улируулан сонгох асуудал байгаа. ТУЗ-ийн ердийн 2 гишүүн чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбогдуулан ердийн гишүүний 2 сул орон тоо гарсан. Үүн дээр шинээр 2 хүнийг нөхөн сонгохоор нэр дэвшүүлж байна. Харин бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй үлдсэн 7 гишүүнийг улируулан сонгуулахаар санал оруулж байна. Хэдийгээр 2 л сул орон тоо гарсан боловч эдгээр ТУЗ-ийн гишүүд маань кумулятив аргаар сонгогдсон гишүүд учир дахиад шинээр бүгдийг нь сонгох шаардлагатай болсон юм.

Ингээд нэр дэвшиж буй хүмүүсийнхээ танилцуулгыг та бүхэнд танилцуулъя. Та бүхэнд тараасан танилцуулга материал дээр мөн нэр дэвшигчдийн танилцуулгыг оруулсан байгаа.

1. ТУЗ-ийн ердийн гишүүнд Янсанжав овогтой Наваан намайг улируулан сонгохоор санал болгож байна. Би 1984 онд төрсөн. 1-р дунд сургууль, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг төгссөн. Номин холдинг ХХК-д 20-аад жил ажиллаж байгаа худалдааны чиглэлийн ийм хүн байна.
2. Алтангэрэл овогтой Норсмааг мөн улируулан сонгохоор нэр дэвшүүлж байна. Төв аймгийн арван жилийн дунд сургууль, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн. Хэд хэдэн компаниудад санхүү, нягтлан бодох бүртгэл, хяналтын чиг үүрэгтэйгээр ажиллаж байсан туршлагатай хүн байгаа.
3. Хүрэлхүү овогтой Эрдэнэбаатарыг мөн улируулан сонгохоор нэр дэвшүүлж байна. 1989 онд төрсөн. Архангай аймгийн дунд сургууль, Санхүү эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлагын мэргэжлээр төгссөн. Мөн бизнесийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалсан, Эдийн засагч чиглэлийн ийм залуу байгаа.
4. Тарбишийн Сарантуяаг улируулан сонгохоор нэр дэвшүүлж байна. Хэнтий аймагт төрсөн. Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг төгссөн. Жижиглэн худалдаа, худалдаа үйлчилгээний чиглэлээр туршлагатай хүн байна.
5. Сэнгэдорж овогтой Хосбаярыг шинээр сул орон тоонд нөхөн сонгохоор нэр дэвшүүлж байна. Ховд аймагт төрсөн. МУИС-ийг шинжээч, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн. Хэд хэдэн компаниудад санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж байсан өндөр туршлагатай хүн байгаа.
6. Жаргалын Дөлгөөнийг шинээр сул орон тоонд нөхөн сонгохоор нэр дэвшүүлж байна. Тэрээр 1995 онд төрсөн. Нийслэлийн 38-р дунд сургууль, ХБНГУ-ын Хайделбергийн их сургууль, МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Санхүү эдийн засгийн сургуульд магистрын зэрэг хамгаалсан хуульч ийм хүнийг ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хувьд дараах 3 хүнийг улируулан сонгуулахаар нэр дэвшүүлж байна.

1. Мөнхнасангийн дамирансүрэн. 1964 онд Багшийн сургуулийг багш мэргэжлээр, 1979 онд тухайн үеийн Удирдлагын их сургуулийг хууль мэргэжлээр төгссөн. 1979-1985 онд Батлан хамгаалах яаманд Хуулийн зөвлөхөөр, 1985-2021 онд Монгол Улсын Дээд шүүхэд шүүгч, зөвлөхөөр ажиллаж байсан. 2023 оны 8-р сараас эхлэн Улсын их дэлгүүр ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байгаа хүн байна.
2. Нанзаддоржийн Энхчимэг. 2000 онд "Түшээ" дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр, 2001 онд МУИС-ийг Түүхч мэргэжлээр төгссөн. Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, 2003 оноос хойш Өмгөөлөгчөөр ажиллаж байгаа, 2015 оноос хойш "Гранд партнерс" ХХН-ийн захирал, 2023 оны 08-р сараас "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна.
3. Мэндсоогийн Ганцацэг. 2000 онд "Түшээ" дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2005 онд "Цагдаагийн академи"-д хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч. "Сүлд" хууль зүйн товчоонд хуульч. Авто тээврийн газарт бүртгэлийн ажилтан. "Хасагт хайрхан" ХЗС-д багш, Иргэний нисэхийн ерөнхий газарт Мэдээллийн ажилтан, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Далайн захиргаанд Хуулийн зөвлөх, Зам тээврийн яаманд Мэргэжилтэн, 2008 оноос өмгөөлөгчөөр, 2023 оны 09-р сараас "Улсын их дэлгүүр" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

За сая танилцуулсан 9 хүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшүүлж байна. Эдгээр нэр дэвшигчдэд та бүхэн саналаа огноо үү гэж хүсэж байна.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Энэ хараат бус 3 гишүүн хувьцаа эзэмшигч юм уу?

Хурлын дарга Я.Наваан: ТУЗ-ийн хараат бус гишүүд хувьцаа эзэмшдэггүй.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: Хувьцаа эзэмшигч нараас өөрсдөө яагаад ТУЗ-ийн хараат бус гишүүнд орохгүй ингээд хамаагүй хүмүүс ороод байдаг юм бол.

Хурлын дарга Я.Наваан: 2023 оны 8-р сард эдгээр хүмүүс нэр дэвшиж орж ирсэн. Хуулийн зохицуулалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг хурлаас сар гаруйн өмнө нийтэд нээлттэй тараадаг. Энд ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгоно гэдэг мэдээлэл очиж байгаа. Энэ үед хүмүүс ТУЗ-ийн гишүүнд нэрээ дэвшүүлэх эрх нь нээлттэй байдаг. Үүний дагуу бол 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн 8 гишүүний орон тоонд 10 хүн нэр дэвшиж өрсөлдөж байсан. Тэр 10 хүнээс 9 нь хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар сонгогдоод ажиллаад явж байгаа. Энэ оны хувьд ТУЗ-ийн 2 ердийн гишүүн чөлөөлөгдөх хүсэлт өгсөн учраас оронд нь шинээр 2 хүн нөхөн сонгуулахаар нэр дэвшүүлж байгаа юм. Энэ удаа ч мөн адил сар гаруй хугацааны өмнө та бүхэнд хурлаар хэлэлцэх асуудлын талаар нээлттэй мэдээлэл өгсөн. Энэ удаа бол нэмэлтээр ТУЗ-ийн гишүүнд нэрээ дэвшүүлсэн хүн алга.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: ТУЗ-ийн гишүүдээс 6 нь Номинд ажилладаг хүмүүс юм байна. Энэ 6 хүнээс хувьцаа эзэмшиж байгаа хүн байна уу?

Хурлын дарга Я.Наваан: ТУЗ-ийн ердийн гишүүд дотроос хувьцаа эзэмшиж буй хүн байхгүй.

Хувьцаа эзэмшигч Гүнжиймаа: За тэгэхээр уучлаарай энэн дээр би санал өгөхгүй. Энэ хувьцаа эзэмшигчдийн хурал болохоос та нарт ерөөсөө хамаагүй. Энд хувьцаа эзэмшиж байгаа хүмүүс орно. Та 6 Номингоо төлөөлөөд орж болно. Бусад хүмүүс нь хувьцаа эзэмшигчид төлөөлж орох ёстой. Тэгж байж энэ хурал чинь шударга болно. Та нартай ярьж хэлэлцэх юм нь бидэнд нээлттэй болно.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Энэ шинээр сул орон тоонд 2 хүн шинээр сонгох тухай зар, сонгон шалгаруулалт явагдсан юм уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: За энэ асуултад би хариулт өгье. Сул орон тоо гарсан нь бол ердийн гишүүний орон тоо байсан. Компанийн тухай хуулийн 88-р зүйлийн 1 дэх хэсэгт саналын эрх бүхий хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналын өгөх эрхтэй байдаг. Үүний дагуу компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн зүгээс сул орон тоонд шинээр сонгогдох нэр дэвшигчийг шууд санал болгосон. ТУЗ-ийн ердийн гишүүнд сонгон шалгаруулалт зарлах үүрэг хүлээдэггүй. 5% гэдэг бол ойролцоогоор 1 сая 840 мянга ширхэг хувьцаа эзэмшигч юм. Харин ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байгаа 3 хүний бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй, сул орон тоо гараагүй учраас нээлттэй сонгон шалгаруулалт зарлах шаардлага үүсээгүй, тэднийг улируулан сонгохоор нэр дэвшүүлж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Өнөөдрийн хуралд ТУЗ-ийн гишүүдээс төлөөлөөд оролцож байгаа хүн байна уу?

Хурлын дарга Я.Наваан: ТУЗ-ийн гишүүдээс Эрдэнэбаатар бид 2 төлөөлөөд оролцож байна.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Өнөөдрийн хурлын ирц 53%-тай гэж байсан. Энэ ирцийг бүрдүүлж байгаа хувьцаа эзэмшигчид нь хэн байгаа юм бэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат: Өнөөдрийн хуралд хэн хэдэн ширхэг хувьцааны саналын эрхтэй оролцож байгааг би хүний нэр дурдаж хэлж болохгүй. Тухайн хүний хувийн нууц учраас. Харин хурлын ирцийг бүрдүүлж байгаа хамгийн өндөр саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоог нь хэлж өгье. Өнөөдрийн хуралд 16,575,925 ширхэг

хувьцаатай хүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь, мөн 950,896 ширхэг хувьцаатай хүний итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байна. Харин 2,049,032 ширхэг хувьцаатай хүн урьдчилан саналын хуудсаар саналаа өгсөн байна. Эдгээр өндөр хувь эзэмшиж байгаа хүмүүсийн саналын эрхийн нийлбэрээр өнөөдрийн хурал хүчин төгөлдөр болж байгаа юм.

Хурлын дарга Я.Наваан: За ингээд хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх 3 асуудалтай холбоотой танилцуулга хийгдэж, хувьцаа эзэмшигч нар санал, хүсэлтээ халж асуултаа асууж дууслаа. Тэгээд одоо та бүхэн өөрсдийн итгэл үнэмшлээр хэлэлцэж буй асуудлуудад саналаа өгөх ёстой байгаа. Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч нарт саналын хуудсыг тарааж өгөөд саналын хуудас бөглөх зааварчилгаа өгөөд явна уу. Санал хураалтын үйл ажиллагааг 20 минутын хугацаанд хийж дуусгаад саналаа нэгтгэе.

Тооллогын комисс: Хувьцаа эзэмшигч нарт цаасаар саналын хуудас тарааж өгнө. Саналын хуудсыг буруу бөглөсөн болон засварласан тохиолдолд дахин 1 удаа саналын хуудас авч дахин бөглөх боломжтой. (гээд Тооллогын комиссын гишүүд саналын хуудсыг хэрхэн бөглөх болон кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох зарчмыг тайлбарлан өгөв)

Хурлын дарга Я.Наваан: За хурлаар хэлэлцсэн асуудлууд дээр хувьцаа эзэмшигчид саналаа өгч дууссан байна. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Г.Өсөхбаяр: Санал хураалтын дүнг танилцуулъя. Энд хувь хүний нууцтай холбоотой асуудал яригддаг учраас хувьцаа эзэмшигчийн нэрийг дурдахгүйгээр санал хураалтын үр дүнг танилцуулэх ёстой гэдгийг урьдчилж хэлбэ.

1-р асуудал буюу Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах асуудалд 19,577,826 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь зөвшөөрсөн, 1119 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.01% нь татгалзсан, 299 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.001% нь санал өгөөгүй түдгэлзсэн байна.

2-р асуудал буюу ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах асуудалд 19,577,826 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь зөвшөөрсөн, 1119 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.01% нь татгалзсан, 299 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 0.001% нь санал өгөөгүй түдгэлзсэн байна.

3-р асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд даргах байдлаар санал өгсөн байна.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын дүнг:

1. Я.Наваанд нийт 19,627,302 ширхэг хувьцааны санал
2. А.Норсмаад нийт 19,627,302 ширхэг хувьцааны санал
3. Х.Эрдэнэбаатарт нийт 19,627,302 ширхэг хувьцааны санал
4. Т.Сарантуяад нийт 19,627,302 ширхэг хувьцааны санал
5. С.Хосбаярт нийт 19,627,302 ширхэг хувьцааны санал
6. Ж.Долгөөнд нийт 19,627,302 ширхэг хувьцааны санал

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын дүнг:

1. М.Дахирансүрэнд нийт 19,626,820 ширхэг хувьцааны санал
2. М.Ганиүцэгт нийт 19,626,820 ширхэг хувьцааны санал
3. Н.Энхчимэгт нийт 19,626,820 ширхэг хувьцааны санал

Хурлын дарга Я.Наваан: Санал хураалтын үр дүнтэй танилцлаа.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувийн саналаар зөвшөөрсөн тул уг асуудал батлагдлаа.

ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.99 хувийн саналаар зөвшөөрсөн тул зардлын төсөө батлагдлаа.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдээс хамгийн олон санал авсан дараах 9 хүн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгогдлоо.

ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Я.Наваан
2. А.Норсмаа
3. Х.Эрдэнэбаатар
4. Т.Сарантуяа
5. С.Хосбаяр
6. Ж.Дөлгөөн

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

1. М.Дамирансүрэн
2. М.Ганцацэг
3. Н.Энхчимэг

За санал хураалтын үр дүн тодорхой болсон учир та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг уншиж танилцуулъя. (гээд дараах төслийг танилцуулав)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар: 01

Угсаа
хэт

ТУЗ-ийн дүрмэлтийг батлах тухай

Мөнгөн Хэрэг Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЭ

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЫН ДАРГА

Я.НАВААН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар: 02

Угсаа-бэлхэл
хэт

ТУЗ-ийн зардлын төсвийг батлах тухай

Мөнгөн Хэрэг Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЭ

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг өөрөөр тогтоолж хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тогтоолын хавсралтаар баталсан зардлын хэмжээг эзэмшигчдийн дагуу өгнөх. Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардлыг үнэмлэхүй төлөсний хавсралтаар батлан төсөвт багтаан гаргах, зардлын зардуулгатай төлөлийн санхүүгийн хайрцаг тэнцвэрт эзэмшигчдийн дагуу бүрэн хайрцагтай Гуйцалгах зааврал Батлан Ажил хийхэн бодолч нэрт далаасхугай.

ХУРЫН ДАРГА

Я.НАВААН

ТӨЛӨӨРӨН ХУРЛАХ ӨӨРДӨЛИЙН 2025 ОНЫ ЗАЛСЫН ТӨСӨӨ

№	Төрөл	Төсөв/млн.төг
1	Т/Засварлалын ажилын гүйцэтгэл, хэргийн урьдчилсан ажил	24,000.00
2	Т/Засварлалын хэрэгт бүр нийлүүлсэн хөрөн хэрэглээний 13 хувь	10,000.00
3	Т/Засварлалын хурал болон ХО-ийн хуралт олохон Бэлтгүүлэх төсөв	800.00
4	Нийт төсөв	42,800.00

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-дугаар
сарын 29-ний өдөр

Дотоод ЦЗ

Хувьцаагч
хурал

Төлөөлөгчид оролцох ажиллагааг гүйцэтгэж байгаа тул

Монгол Улсын 4-дүгээр үйлдлийн хуулийн 37-дүгээр зүйлээр, БХ 1.1 дэх хууль, хуулийн дүрмийн 7.3.4 дэх зэрэгт, Хувьцаа
эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тулгуурлан, ТӨГТӨӨХ НБ

1. Монголын Төвийн үйлдлийн засварлалын ажилын гүйцэтгэл дүрмийн 1.1 дэх хууль, хуулийн дүрмийн 7.3.4 дэх зэрэгт, Хувьцаа
эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тулгуурлан, ТӨГТӨӨХ НБ
 - 1.1. Явсагчдын Нэгдсэн үйлдлийн засварлалын ажил
 - 1.2. Алтангэрлийн Нэгдсэн үйлдлийн засварлалын ажил
 - 1.3. Төрөөлөгчид Саяатуйл үйлдлийн засварлалын ажил
 - 1.4. Хэрэгсэлтүүд: Хэрэгсэлтүүд үйлдлийн засварлалын ажил
 - 1.5. Хэрэгсэлтүүд: Хэрэгсэлтүүд үйлдлийн засварлалын ажил
 - 1.6. Жаргалын Дотоодын үйлдлийн засварлалын ажил
2. Монголын Төвийн үйлдлийн засварлалын хэрэгт бүр нийлүүлсэн хөрөн хэрэглээний 13 хувь
 - 2.1. Монголын Төвийн үйлдлийн засварлалын ажил
 - 2.2. Алтангэрлийн Нэгдсэн үйлдлийн засварлалын ажил
 - 2.3. Төрөөлөгчид Саяатуйл үйлдлийн засварлалын ажил
3. Хувьцаагчдын хурал, тогтоол, хуулийн дүрмийн 7.3.4 дэх хууль, хуулийн дүрмийн 7.3.4 дэх зэрэгт, Хувьцаа
эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тулгуурлан, ТӨГТӨӨХ НБ
4. Шийдвэр гаргасны дараахь ажиллагааг гүйцэтгэж байгаа тул

ХУРАЛЫН ДАРГА

Я.НАВААН

Ингээд хурлын үйл ажиллагааг дуусгая. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нартаа
баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 13:00 цагт дуусав.

ТЭМДЭГЛЭЛИЙГ ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН

ХУРАЛЫН ДАРГА

Я.НАВААН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ӨЛЗИЙБАТ

